



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/272

Мөрөн сум

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс  
урьдчилан сэргийлэх дархлаажуулалт  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 09 дүгээр зүйлийн 9.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/177 тоот тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шүлхий өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтыг бүх сумдад, Булган, Архангай аймагтай хил залгаа Галт, Жаргалант, Төмөрбулаг, Рашаант, Тариалан, Төмөрбулаг сумдын үхэр сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсугай

2. Ажлын хэсгийг зохион байгуулан шаардагдах хүн хүч, шатахуун, автомашинаар хангахыг сумдын Засаг дарга нарт, ажлын явц, чанар гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилж олгож, мэргэжил арга зүйгээр ханган, тайлан мэдээ, акт, санхүүгийн баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ